

ЦАХИМ ӨГӨГДЛИЙН ХАЙРЦАГ энэ нь шуудангийн хайрцгийн цахим хэлбэр (цахим шуудан биш) бөгөөд та бүх эрх бүхий захиргааны байгууллагуудтай харилцах боломжтой.

- Энэ нь тасралтгүй ажиллах ба та хүссэн үедээ, хаана ч байсан шуудангаа унших боломжтой.
- Цахим өгөгдлийн хайрцгаар дамжуулсан бүх зүйл үнэ төлбөргүй байдаг.
- Бүх албан ёсны зурвасууд уншсанаас хойш 90 хоногийн турш (хүргэснээс хойш бүс) энд хадгалдаг бөгөөд дараа нь устгадаг.

БИД САНАЛ БОЛГОЖ БАЙНА!

- **Долоо хоногт нэг удаа цахим өгөгдлийн хайрцгийг шалгана уу!** – захиргааны байгууллаас танд илгээсэн баримт бичгийг тухайн хугацаанд уншаагүй байсан ч цахим өгөгдлийн хайрцагт (хуурамч хүргэлт үүсэж) хүргэснээс хойш 10 хоногийн дараа хүлээн авсан гэж үзнэ!
- **Илгээсэн зурвасыг бүрэн хэлбэрээр хадгална - цахим гарын үсэгтэй дугтуй мөн цагийн тамга зэрэг багтана.** Энэ тохиолдолд бичиг баримт нь эх хувь гэж тооцогдох бөгөөд хүчинтэй хэвээр байна.
 - o Хэрэв та бичиг баримт хэн нэг лүү хүргэх/илгээх шаардлагатай бол бүрэн хэлбэрээр нь хүргүүлэх ёстой. Жишээлбэл, цахим шуудангаар илгээх эсвэл бүрэн захидлыг дугтуйнд хийж CD-гээр илгээнэ үү.

АНХААР! Цахим өгөгдлийн хайрцгаас ирсэн зурвас/баримт бичгийн ердийн хуулбар нь эх хувь шиг хүчинтэй байдаггүй.

- Хэрэв та зурвасыг цаасан хэлбэрээр (хүчинтэй эх хувийг) хүсвэл Czech POINT-оос очих шаардлагатай (энэ нь төлбөртэй болно).

ОРШИН СУУГАА ГАЗАРТАЙ ШУУДАНГИЙН ХАЙРЦАГ ТЭМДЭГЛЭХ БОЛОМЖГҮЙ ЭСВЭЛ ОГТ ШУУДАНГИЙН ХАЙРЦАГГҮЙ ХҮМҮҮСТ ЦАХИМ ӨГӨГДЛИЙН ХАЙРЦАГТАЙ БОЛХИЙГ БИД ЗӨВЛӨЖ БАЙНА.

Цахим өгөгдлийн хайрцагтай болох:

Та "цахим өгөгдлийн хайрцаг үүсгэх хүсэлт"-ээр дамжуулан дараах аргуудаар цахим өгөгдлийн хайрцагтай болно:

- **цахимаар** www.mojedatovaschranka.cz порталаар эсвэл Иргэний үнэмлэхээр дамжуулан (жишээлбэл, банкны үнэмлэх, цахим иргэний үнэмлэх, гар утасны түлхүүр гм.).
- **өөрийн биеэр** Czech POINT дээр (оршин суух зөвшөөрөл эсвэл иргэний үнэмлэх үзүүлж мөн нэвтрэх мэдээллийг илгээх хүчинтэй хаягийг мэдэгдэх шаардлагатай)
- **бичгээр** (албан ёсоор баталгаажуулсан гарын үсэгтэй өргөдөл). Өргөдлийн маягтыг дараах хаягаар илгээнэ үү: Digitální a informační agentura, Na vápence 915/14, 130 00 Praha 3.

Нэвтрэх мэдээлэл - хэрэглэгчийн нэр, нууц үг

- Танд шуудангаар эсвэл цахим шуудангаар ирэх болно. БНЧУ-аас гадна хаягаар хүргэлт хийх боломжтой.
- Хүлээн авсны дараа цахим өгөгдлийн хайрцагт нэвтрэнэ үү www.mojedatovaschranka.cz.

Цахим өгөгдлийн хайрцгийн тухай илүү их мэдээллийг эндээс:

- <https://irsczech.com/datova-schranka-a-cizinci>
- <https://info.mojedatovaschranka.cz/info/cs/66.html>

***IDENTITA OBČANA (ИРГЭНИЙГ ТАНИХ)** - Цахим үнэмлэхийг бий болгохын тулд гадаадын иргэд БНЧУ-ын нутаг дэвсгэрт хүчинтэй оршин суух зөвшөөрлөө хэрэглэнэ. Бүртгэл болон дараагийн баталгаажуулалтыг Czech POINT дээр биечлэн хийнэ.

Цахим таних талаарх дэлгэрэнгүй мэдээллийг эндээс: <https://info.identitaobcana.cz/>

